



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2016 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 05

Сэвхүүл

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.


2. Сумын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр тайлагнахыг Засаг дарга /В.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ё.БАТЦЭНГЭЛ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн
22-р хуралдааны 05 дугаар тогтоолын
хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

“ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ” ЖИЛ

2016.01.06

№	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөрөнгийн эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хугацаа	Хариуцах Үбайгууллага
Нэг: “Ажилтай орлоготой Монгол хүн” бодлогыг хэрэгжүүлэх						
1.1. Нийгмийн хамгааллын бодлогын чиглэлээр						
Зорилт: Ажилгүйдлийг бууруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.						
1.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх 1.1. АХТ	1.1.1. Сумын ажилгүй иргэдийг түр болон байнгын ажлын байранд зуучилна.	УТ	Түр ажлын байраар - 60 иргэн, байнгын ажлын байраар - 50 иргэнийг хангаснаар өрхийн орлого нэмэгдэж ажилгүйдлийн түвшин буурна.	Жилдээ	ЗДТГ Хөдөлмөрийн мэргэжилтэн
2.		1.1.2. Хагас бүтэн өнчин хүүхдийг нийгмийн халамжид хамруулж, боловсрол олгох ажлыг зохион байгуулна.	УТ	Хагас, бүтэн өнчин хүүхэд бүрий өрхийн орлого нэмэгдэж хүүхдэд мэргэжил эзэмших нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	ЗДТГ Нийгмийн халамжийн мэргэжилтэн
3.		1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид дэмжлэг урамшуулал олгоно.	ОНТ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах байгууллага, аж ахуйн нэгж нэмэгдсэн байна.	Жилдээ	ЗДТГ Хөдөлмөрийн мэргэжилтэн
4.		1.1.4. Малчин болон ажилгүй иргэдийг эрүүл мэндийн болон сайн дурын нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлнэ.	ХХО	Малчин болон ажилгүй иргэдийн 10-аас доошгүй хувийг эрүүл мэндийн болон сайн дурын нийгмийн даатгалд хамруулсан байна.	Жилдээ	ЗДТГ Нийгмийн даатгалын байцаагч
5.		1.1.5. Орлого багатай өрхөд ам бүлийн тоог үндэслэн хүнсний эрхийн бичигт хамруулна.	ОНТ	8 өрхийн гишүүдийг хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлнэ.	Жилдээ	ЗДТГ Нийгмийн халамжийн Мэргэжилтэн

6.		1.1.6. “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	ОНХС	Хүүхэд, залуучуудын нийгмийн өмнө хүлээх хариуцлага дээшилж, нийгмийн идэвх сайжирна.	Жилдээ	ЗДТГ
7.		1.1.7. “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	ОНХС	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх сайжирна.	Жилдээ	ЗДТГ
8.		1.1.8 Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэтгэвэр, тэтгэмжид бүрэн хамруулна.	ОНТ	Өрхийн орлого нэмэгдэж, амьжиргааны түвшин дээшилнэ.	Жилдээ	ЗДТГ Нийгмийн халамжийн мэргэжилтэн
9.		1.1.9. “Ажилгүйдлийг бууруулах арга зам” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	СХС ЖДҮХС ХЭДС	Өрхийн үйлдвэрлэл нэмэгдэж түр болон байнгын ажлын байраар хангагдан өрхийн орлого өснө.	Жилдээ	ЗДТГ Хөдөлмөрийн мэргэжилтэн

1.2. Эдийн засгийн бодлогын чиглэлээр

Зорилт: Дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, иргэдийн ая тухтай, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

10.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 1.2.	1.2.1. “Сумдад ахуйн үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-т хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	ХХО	Ахуйн үйлчилгээний үйл ажиллагаа тогтмолжиж иргэд төрөл бүрийн үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангагдсан байна.	Жилдээ	ЗДТГ
11.		1.2.2. Төсөвт байгууллагуудын санхүүжилт, түүнд гүйцэтгэлээр тавих хяналтыг сайжруулж татварын орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлнэ.	ОНТ	Төсвийг зориулалтын дагуу зарцуулж өр, авлага үүсгэхгүй ажилласан байна.	Жилдээ	ЗДТГ Санхүүгийн алба
12.		1.2.3. Сумын 2017 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтын асуудлыг иргэдийн оролцоонд тулгуурлан төлөвлөж, орон нутгийн хөгжлийн төсөл, төсвийг батлуулна.	-	Хуулийн хэрэгжилт хангагдаж, орон нутгийн хөгжил иргэдийн оролцоонд тулгуурласан байна.	2, 3-р улирал	ЗДТГ
13.		1.2.4. Сумын төв зууханд урсгал засвар хийнэ.	БХ	Зуухны үйл ажиллагаа сайжирч иргэд найдвартай дулаанаар хангагдана.	Жилдээ	“Илчлэг-Шивээ” ОНӨҮГ
14.		1.2.5. Сумын өргөх станцын барилгад их засвар хийж, ус	ОНХС	Иргэд хатуулаг багатай цэвэршүүлсэн	Жилдээ	ЗДТГ

	цэвэршүүлэгч тоног төхөөрөмж суурилуулна.		усаар хангагдана.		“Илчлэг-Шивээ” ОНӨҮГ
15.	1.2.6. Сумын төвийн бохирын цэвэрлэх байгууламжийн зураг, төсвийг хийлгэнэ.	ОНХС	Сумын төвийн бохирын цэвэрлэх байгууламжийг барих нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	ЗДТГ
16.	1.2.7. Нийтийн эзэмшлийн дэд бүтцийг сайжруулна. /250 м халаалт, цэвэр усны шугам солих/	ОНХС	Хэрэглэгчийг найдвартай дулаан, цэвэр усаар хангана.	Жилдээ	ЗДТГ
17.	1.2.8. Эрчимжсэн мал аж ахуйн бүсийн газарт цахилгааны шугам татаж, худаг гаргах	ОНХС	Эрчимжсэн мал аж ахуйн суурьших тав тухтай орчин бүрдэж сумын төвийн ногоон байгууламж эрсдлээс хамгаалагдана.	2, 3-р улирал	ЗДТГ
18.	1.2.9. “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ-ын нүүрсний машинд их засвар хийх	БХ	Нүүрсний татан авалт бүрэн хангагдаж хөрөнгө хэмнэгдэнэ.	1-2-р улирал	“Илчлэг-Шивээ” ОНӨҮГ
19.	1.2.10. Цэцэрлэгийн барилгын дээвэрт засвар хийнэ.	ОНХС	Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд хөгжих боломж бүрдэнэ.	2-р улирал	ЗДТГ
20.	1.2.11. Сумын хүндэтгэлийн хаалга хийнэ.	ОНХС	Иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.	2-р улирал	ЗДТГ
21.	1.2.12. Нийтийн гэрэлтүүлгүүдийн урсгал засвар, үйлчилгээ /төв талбай, гэрэлт цамхаг, ногоон байгууламж, зүүн гэр хороолол/ хийнэ.	ОНХС	Сумын өнгө үзэмж сайжирч иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	ЗДТГ
22.	1.2.13. Сумын төвийг камержуулна.	ОНХС	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, илрүүлэлт сайжирч хяналт тавих боломж бүрдэнэ.	Жилдээ	ЗДТГ ЦХ
23.	1.2.14. Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглалтанд оруулна.	УТХ	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.	2-р улирал	ЗДТГ

24.	1.2.15. Сургуулийн шинэ барилга барих асуудлыг холбогдох газруудад уламжилна.	-	ЕБСургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын хөрөнгийн асуудал шийдвэрлэгдэнэ.	Жилдээ	ЗДТГ
25.	1.2.16. Соёлын төвийн барилгын асуудлыг холбогдох газруудад уламжилна.	-	Соёлын төвийн шинэ барилгын хөрөнгийн асуудал шийдвэрлэгдэнэ.	Жилдээ	ЗДТГ

1.3. Хөдөө аж ахуйн бодлогын чиглэлээр

Зорилт: Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийг дэмжинэ.

26.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 1.3.	1.3.1. Мал аж ахуй, газар тариалан, гар урлал, барилгын материалын үйлдвэрлэл, бүх төрлийн үйлчилгээг дэмжин ажиллана.	СХС, ЖДҮДС, ХЭДС, ХХО	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтмолжиж ажлын байр нэмэгдэнэ.	Жилдээ	ЗДТГ
27.		1.3.2. Баялаг бүтээгчдийг дэмжих холбоотой хамтран ажиллана.	-	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтмолжиж уяалдаа холбоо сайжирна.	Жилдээ	ЗДТГ Хөдөлмөрийн мэргэжилтэн
28.		1.3.3. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гарган ажиллана.	ОНТ	Бэлчээрийн даацыг тодорхойлж зохистой ашиглах нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	МЭҮТ
29.		1.3.4. Хоршооны гишүүдийн бэлтгэсэн ноос, арьс ширэнд хууль, журмын дагуу урамшуулал олгуулах ажлыг зохион байгуулна.	ОНТ	Хоршоонд элсэх малчдын тоо нэмэгдэж, өрхийн орлого дээшилнэ.	Жилдээ	МЭҮТ
30.		1.3.5. Өндөр ашиг шимтэй хээлтэгч малыг үржилд сайжруулагчаар ашиглана.	ХХО	Сумын малын чанар сайжирч, ашиг шимийн гарц нэмэгдэнэ.	Жилдээ	МЭҮТ
31.		1.3.6. “Малжуулах журам”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	ОНХС	Малчдын орлого нэмэгдэж, малын тоо толгой өснө.	Жилдээ	МЭҮТ
32.		1.3.7. Усалгаатай тариалан эрхлэлтийг дэмжиж сумын хүн амын хүнсний ногооны нийлүүлэлтийг		Усалгаатай тариалангийн талбайг 10 га-д хүргэж, сумын хүн амын хүнсний ногооны	2, 3, 4 -р улирал	МЭҮТ

		нэмэгдүүлнэ.	ХХО	хэрэгцээний 25%-ийг хангана.		
33.		1.3.8. Мал сүргийг халдварт паразиттах өвчнөөс эмчлэн, сэргийлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	УТ	Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын тоо толгой нэмэгдэнэ.	Жилдээ	МЭҮТ
34.		1.3.9. Малын индексжүүлсэн даатгалд мал сүргийг бүртгэж даатгах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	ХХО	Мал сүргийн 3%-ийг хамруулсан байна.	Жилдээ	МЭҮТ
35.		1.3.10. Өвс тэжээлийн нөөцийг чанаржуулна.	ОНХС	Сумын нөөцөд байгаа өвс, тэжээлийн чанар сайжирсан байна.	Жилдээ	МЭҮТ
36.		1.3.11. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй иргэдэд газрыг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Эрчимжсэн мал аж ахуй нэг цэгт төвлөрч суурьшлын бүс нээгдэх эхлэл тавигдана.	Жилдээ	МЭҮТ
37.		1.3.12. Золбин нохой, муур устгах ажлыг зохион байгуулна.	ОНХС	Иргэд аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.	Жилдээ	МЭҮТ
38.		1.3.13. Гахай, шувууны аж ахуйг нэмэгдүүлнэ.	-	Гахай, шувууны аж ахуй эрхлэгч иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Жилдээ	МЭҮТ
39.		1.3.14. Мал сүргийг ээмэгжүүлэн, цахим бүртгэлд оруулж, мэдээллийн санг баяжуулна.	ХХО	Цөм сүрэг нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	МЭҮТ
40.		1.3.15. Мах, ногооны зоорины ашиглалтыг нэмэгдүүлнэ.	ХХО	Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангасан эрүүл ахуйн стандартад нийцсэн мах, ногоог хүнсэнд хэрэглэнэ.	Жилдээ	МЭҮТ
41.		1.3.16. “Нэг баг – Нэг хоршоо”, “Элбэг дэлбэг - Цагаан сар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	ОНТ	Суманд үйлдвэрлэл эрхлэгч баг, хоршоо, иргэдийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн байна.	1,3-р улиралд	МЭҮТ

42.	1.3.17. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах “Гар худаг”, “Хадлан”, “Ургац” болзолт уралдаануудад оролцоно.	АОНХС ОНТ	Сумын нутаг дэвсгэрт худгын тоо, малчдын өвсний нөөц, иргэдийн хүнсний ногооны хүртээмж тус тус нэмэгдсэн байна.	3,4-р улирал	МЭҮТ
43.	1.3.18. Хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.	ХХО	Хүлэмжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, аюулгүй хүнсээр хангагдана.	Жилдээ	МЭҮТ
44.	1.3.19. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах ажлыг айл өрх, албан байгууллагуудын дунд өрнүүлж, сайн чанарын үр суулгацаар хангана.	ТЭДС	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах айл өрх, албан байгууллагуудын тоо нэмэгдсэн байна	Жилдээ	МЭҮТ
45.	1.3.20. Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн стандартыг бүх түвшинд мөрдөн хэрэгжүүлнэ.	ХХО	Иргэд эрүүл аюулгүй баталгаат хүнсээр хангагдаж, үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого нэмэгдэнэ.	Жилдээ	МЭҮТ

Хоёр: “Эрүүл чийрэг Монгол хүн” бодлогыг хэрэгжүүлэх

2.1. Эрүүл мэндийн бодлогын чиглэлээр

Зорилт: Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэнэ.

46.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 2.	2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	ОНТ ОНХС	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрүүл зөв амьдрах зан үйл төлөвшинэ.	Сар бүр	Эрүүл мэндийн төв
47.		2.1.2. Иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээний мэдээллийг хүргэнэ.	ОНТ	Эрүүл мэндийн үйлчилгээний мэдээлэл иргэдэд ил тод болсон байна.	Жилдээ	Эрүүл мэндийн төв
48.		2.1.3. “Оюу-Үүдэн” эмнэлэгтэй хамтран ажиллана.	ОНТ ОНХС	Зорилтот бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.	Жилдээ	Эрүүл мэндийн төв
49.		2.1.4. 0-16 насны хүүхдүүдийн амны хөндийн өвчлөлийг эмчилнэ.	УТ	0-16 насны хүүхдүүдийн 20 хувь эмчлэгдсэн байна.	Жилдээ	Эрүүл мэндийн төв
50.		2.1.5. Эмнэлгийн мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтанд хамруулна.	ОНТ	Эмнэлгийн 2 мэргэжилтэнг өрхийн болон хүүхдийн сувилагчаар мэргэшүүлсэн байна.	Жилдээ	Эрүүл мэндийн төв
51.		2.1.6. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлж, үзлэг шинжилгээнд	ОНТ	Үзлэг шинжилгээний үр дүнгээс шалтгаалан зөвлөгөө өгөх, дараагийн шатны эмнэлгийн тусламж үйлчилгээнд	Жилдээ	Эрүүл мэндийн төв

		хамруулна.		хамруулан эмчлүүлэх арга хэмжээг авсан байна.		
52.		2.1.7. Байнгын асаргаа шаардлагатай иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.	ОНТ	Асаргаа сувилгаа нь сайжирч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тогтмолжсон байна.	Жилдээ	Эрүүл мэндийн төв
53.		2.1.8. Эмийн сан байгуулах санал санаачлагыг дэмжин ажиллана.	ХХО	Иргэд хямд өртөг бүхий эм, эмийн бэлдмэлээр хангагдаж эм, эмийн бэлдмэлийн хүртээмж нэмэгдэнэ.	Жилдээ	ЗДТГ
54.		2.1.9. Эмнэлгийн тоноглолтой автомашин авна.	ОНХС	Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ стандартын дагуу шуурхай хүргэгдэнэ.	Жилдээ	ЗДТГ
Гурав: “Эрдэм боловсролтой Монгол Хүн” бодлогыг хэрэгжүүлэх.						
3.1. Боловсролын бодлогын чиглэлээр						
Зорилт: Хүүхэд нэг бүрийн чадварын ахиц амжилтыг сайжруулна						
55.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 3.	3.1.1. “Зөв монгол хүүхэд ” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	ОНТ	Багш нэг бүрийн багшлах ур чадварыг сайжруулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлнэ.	Жилдээ	3-р сургууль 3-р цэцэрлэг
56.		3.1.2. Сургуулийн ширээ, сандал, цэцэрлэгийн тоглоом наадгай, зөөлөн эдлэлийг нэмэгдүүлнэ.	ОНХС	Сургалтын орчин сайжирна.	Жилдээ	3-р сургууль 3-р цэцэрлэг
57.		3.1.3. Хүүхэд нэг бүрийн чадварын ахиц амжилтыг сайжруулна.	ОНТ	Хүүхэд нэг бүрийн сурлагын ахиц амжилтыг 0.1 %-иар ахиулсан байна.	Жилдээ	3-р сургууль 3-р цэцэрлэг
58.		3.1.4. Насан туршийн боловсролын сургалтын чанарыг сайжруулах, танхимыг тохижуулна.	ОНТ ОНХС	Сургалтын орчин бүрдэж, суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшүүлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгоно.	Жилдээ	ЗДТГ НТБ-ын багш
59.		3.1.5. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж чанарыг сайжруулах	ОНТ	Тухайн жилд хамрагдах сургуулийн өмнөх насны хүүхдийг 100% хамруулсан байна.	Жилдээ	3-р цэцэрлэг
60.		3.1.6. СӨБ-ын сургалтын “ЦӨМ” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	УТ	СӨБ-ыг хүүхэд нэг бүрт тэгш хүртээмжтэй хүргэнэ.	Жилдээ	3-р сургууль 3-р цэцэрлэг
61.		3.1.7. Бага боловсролын “ЦӨМ” хөтөлбөрийг эрчимжүүлж, суурь боловсролын “ЦӨМ” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.		Хүүхэд нэг бүрийн чадварын ахиц амжилт сайжирна.	Жилдээ	3-р цэцэрлэг
62.	3.1.8. Цэцэрлэгийн сургалтын орчинг	АОНХС	Үйл ажиллагаа ил тод болж хяналт тавих	3-р улирал	3-р цэцэрлэг	

		бүхэлд нь камержуулна.		нөхцөл бүрдэнэ.		
63.		3.1.9. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлж эхэлнэ.	УТ	Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах шаардлага хангагдаж, эрүүл аюулгүй орчинд үйлчилгээг зохион байгуулж эхэлсэн байна.	Жилдээ	ЗДТГ
Зорилт: Соёл урлаг, спортын чанар хүртээмжийг дээшлүүлж угийн бичиг хөтлөх ажлыг сайжруулна.						
64.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 3.1.	3.1.10. Хөдөөгийн багийн иргэдэд Соёлын явуулын үйлчилгээг хүргэнэ.	ОНТ	Хөдөөгийн иргэдэд соёлын үйлчилгээг ойртуулж, тэдний урлаг, соёлын ажилд оролцох идэвхийг сайжруулсан байна.	3-р улирал	Соёлын төв
65.		3.1.11. Ардын авьяастнаар бүрдсэн ур чадвартай орон тооны бус 8-10 хүнтэй урлагийн чадварлаг баг бүрдүүлнэ.	ОНТ	Соёл урлагийн үйлчилгээний чанар нэмэгдэнэ.	Жилдээ	Соёлын төв
66.		3.1.12. Үндэсний урлагийн хамтарсан тоглолтыг зохион байгуулна.	УТ	Авьяастнуудын тоо нэмэгдэж бүртгэл мэдээллийн сан баяжигдсан байна.	4-р улирал	Соёлын төв
67.		3.1.13. Номын сангийн уншигч, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулна.	ОНТ	Уншигч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан байна.	Жилдээ	Соёлын төв
68.		3.1.14. "Угийн бичиг" хөтлөх арга зүйн талаарх сургалт зохион байгуулж, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлнэ.	ОНТ	Угийн бичиг хөтлөх өрхийн тоог нэмэгдүүлж нийт хүн амын 30 %-г хамруулсан байна.	Жилдээ	Соёлын төв ЗДТГ
69.		3.1.15. Орон нутаг судлах танхимыг түүхэн үзмэрээр баяжуулна.	ОНТ ОНХС	Орон нутаг судлах танхимыг үзмэрээр баяжуулж, тохижуулсан байна.	Жилдээ	Соёлын төв
70.		3.1.16. Цэнгэлдэх хүрээлэнг түшиглэн нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулна.	ОНТ ОНХС	Иргэд хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэгдэж, Цэнгэлдэх хүрээлэнгийн ашиглалт сайжирсан байна.	Жилдээ	ЗДТГ

71.		3.1.17. Сумын Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ыг зохион байгуулна.	ОНТ ОНХС	Иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, нийгмийн идэвх нь сайжирна.	2-р улиралд	ЗДТГ
Дөрөв: “Аюулгүй орчинтой Монгол хүн” бодлогыг хэрэгжүүлэх.						
4.1. Байгаль орчны бодлогын чиглэлээр						
Зорилт: Орчны бохирдол, доройтлыг бууруулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.						
72.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 4.	4.1.1. Иргэдийн дунд экологийн чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулна.	ОНТ	Иргэдийн экологийн мэдлэг дээшилнэ.	Жилдээ	ЗДТГ БОХУБ
73.		4.1.2. Бүх нийтээр мод тарих өдрийг иргэн, АБ, ААН-ийн оролцоотойгоор зохион байгуулж, авто замын дагуух тарьсан модыг хашаажуулна.	ОНТ ОНХС	Сумын ногоон байгууламж нэмэгдэж тарьсан модыг хамгаалалтанд авсан байна.	2, 3-р улирал	ЗДТГ Төсвийн байгууллагууд, иргэд, ААН
74.		4.1.3. Сумын төвийн ногоон байгууламжуудад усалгааны систем байгуулж арчилгаа хийх, тарьц суулгац тарьж, хамгаална.	ОНХС	Тарьсан мод суулгац, ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, хамгаалалт сайжирсан байна.	2, 3-р улирал	ЗДТГ БОХУБ
75.		4.1.4. Сумын ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын хашааг шинэчилж, тэмдэгжүүлнэ.	ОНХС	Хүн амын ундны усны аюулгүй байдал хангагдана.	2-р улиралд	ЗДТГ БОХУБ
76.		4.1.5. Хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигч, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг чанартай гүйцэтгүүлнэ.	ХХО	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийлгэсэн байна.	2, 3-р улирал	ЗДТГ БОХУБ

77.		4.1.6. Сумын хог хаягдлын 1, 2 –р цэгийг цэвэрлэх, дарж булах, нөхөн сэргээх ажлыг хийнэ. \баруун хогийн цэг\	ОНХС	Байгалийн тэнцвэрт байдал хадгалагдаж, иргэдийн аюулгүй эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	ЗДТГ БОХУБ
78.		4.1.7. Орон нутгийн тусгай хамгаалалтанд бүртгэлтэй газрын хамгаалалтыг сайжруулж тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж хамгаалалтын дэглэмийг мөрдүүлнэ.	ОНТ	Түүхийн дурсгалт газрын эх хамгаалагдаж, булаг шандын ундарга сайжирсан байна.	3-р улирал	ЗДТГ
79.		4.1.8. Ахуйн хог хаягдал тээвэрлэлтийн менежментийг сайжруулна.	ОНХС	Эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.	Жилдээ	ЗДТГ

Зорилт: Газар зохион байгуулалтын бодлогыг оновчтой, ил тод, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлнэ.

80.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 4.	4.1.9. Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийг нээлттэй зохион байгуулна.	ОНТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт хэрэгжин иргэн, аж ахуйн нэгж байгууллага өөрийн үл хөдлөх хөрөнгөтэй болсон байна.	2-р улирал	ЗДТГ
81.		4.1.10. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулийн дагуу дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар олгоно.	-	Орон нутгийн орлогод хөрөнгө төвлөрч, газар эдийн засгийн эргэлтэнд орсон байна.	2-р улирал	ЗДТГ
82.		4.1.11. Эрчимжсэн мал аж ахуйн бүс газрыг иргэдэд хуулийн дагуу эзэмшилд нь хуваарилж олгоно.	-	Иргэд эзэмшлийн газартай болж, сумын төвийн мал аж ахуй эрхэлдэг иргэд нэгдсэн байршилд төвлөрсөн байна.	2, 3-р улирал	ЗДТГ

Тав: “Эрх чөлөөтэй Монгол хүн” бодлогыг хэрэгжүүлэх.

5.1. Засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээнд

Зорилт: Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, ил тод байдлыг хангуулна.

83.	СЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ 5.	5.1.1. Иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг "Иргэний танхим"-тай хамтран зохион байгуулна.	ОНТ ХЭДС ОНХС	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж хуулийн хэрэгжилт сайжирна.	Жилдээ	ЗДТГ Иргэний танхим
84.		5.1.2. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.	ОНТ	Төрийн байгууллагаас иргэдтэй харилцах уялдаа холбоо сайжирч иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.	Жилдээ	ЗДТГ Төсвийн байгууллагууд
85.		5.1.3. Төрийн албан хаагчдын "Сургалт", "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	ОНТ	Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар дээшилж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа сайжирна.	Жилдээ	ЗДТГ Төсвийн байгууллагууд
86.		5.1.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгоно.	-	Төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.	Жилдээ	Санхүүгийн алба
87.		5.1.5. Сумын вэб сайтыг сайжруулж мэдээ, мэдээллээр хангана.	-	Сумын вэб сайтыг ашиглалт нэмэгдэж иргэд мэдээлэл авах нөхцөл бүрдсэн байна.	Жилдээ	ЗДТГ
88.		5.1.6. Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулна.	ОНТ	Иргэд гамшгаас хамгаалах дадлага, сургалтанд хамрагдсан байна.	Улирал бүр	ЗДТГ
89.		5.1.7. "Иргэдээ сонсьё" уулзалт өдөрлөгийг зохион байгуулна.	ОНТ	Төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж иргэдэд тулгамдаж буй асуудлыг шуурхай шийдвэрлэсэн байна.	2-р улиралд	ЗДТГ
90.		5.1.8. "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулна.	-	Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, түргэн шуурхай хүргэнэ.	1, 2-р улиралд	ЗДТГ
91.		5.1.9. Багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулна.	-	Иргэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн дээд шатны болон холбогдох байгууллагуудаар түргэн шуурхай шийдвэрлүүлсэн байна.	Улирал бүр	Багийн Засаг дарга нар
92.		5.1.10. Төрийн бүх шатны худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж, цахим худалдан авалт зохион байгуулна.	-	Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдал хангагдаж, цахим худалдан авалт сайжирсан байна.	Жилдээ	ЗДТГ
93.		5.1.11. Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	ОНТ ОНХС	Хамтын ажиллагааны уялдаа холбоо сайжирч ТББ-уудын үйл ажиллагаа жигдэрнэ.	Жилдээ	ЗДТГ ТББ-ууд
94.		5.1.12. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг	ОНТ	Гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээлэл дээшилнэ.	Жилдээ	ЗДТГ ЦХ

		эрчимжүүлнэ.					
95.		5.1.13. Бүх төсвийн байгууллагуудыг вэб сайттай болгоно.	УТ	Үйл ажиллагаа нээлттэй, ил тод болно.	Жилдээ	ЗДТГ	

Товчилсон нэрийн тайлал

ЗДТГ – Засаг даргын Тамгын газар

НА- Нийгмийн ажилтан

НБАХМ- Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

НЗЭАХМ- Нутгийн захиргааны эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

БОХУБ – Байгаль орчны хяналтын улсын байцаагч

НДБ- Нийгмийн даатгалын байцаагч

МЭҮТ- Мал эмнэлэг үржлийн тасаг

ШОХК – “Шивээ-Овоо” ХК

ИШОНӨҮГ – “Илчлэг Шивээ” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

ЦХ- Цагдаагийн хэсэг

ХБИ- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

УТ – Улсын төсөв

ОНХС – Орон нутаг хөгжлийн сан

ОНТ – Орон нутгийн төсөв

СХС – Сум хөгжүүлэх сан

ХХО – Хувийн хөрөнгө оруулалт

ЖДҮДС – Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан

ТЭДС - Тариалан эрхлэгчдийг дэмжих сан

ГЗБ- Газар зохион байгуулалт

СЗДҮАХ- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

АХТ- Арга хэмжээнд тусгагдсан

БХ- Байгууллагын хөрөнгө

ХЭДС- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

ОУБХ- Олон улсын байгууллагын хөрөнгө

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР